Төрийн албаны зөвлөлийн
2022 оны 05 сарын 11-ний өдрийн
323 дугаар тогтоолын 10 дугаар хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

| | |
|---|---|
| Хууль тогтоомжийн нэр огноо: | |
| Дагаж мөрдөх огноо: | |
| Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо | |

| Байгууллагын нэр: | Нэгжийн нэр: |
|---|---|
| Нийслэлийн Аялал жуулчлалын газар | Бодлогын хэрэгжилтийн хэлтэс |

| Албан тушаалын нэр: | Албан тушаалын ангилал, зэрэглэл: |
|---|---|
| Эвент хариуцсан мэргэжилтэн | Дэс түшмэл, ТЗ-5 |

| Ажлын цаг | Ажлын байрны албан ёсны байршил |
|---|---|
| Ажлын өдөр 8 цаг | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Самбуугийн гудамж, Бага тойруу-15, Нийслэлийн Засаг захиргааны 4 дүгээр байр. |

| Хөдөлмөрийн нөхцөл: | Онцгой нөхцөл |
|---|---|
| Хэвийн | Хамаарахгүй |

## II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Аялал жуулчлалын салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хүрээнд эвентүүдийг зохион байгуулж аялал жуулчлалыг хөгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж гүйцэтгэлийн үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцна.

| Албан тушаалын зорилт:<br><br>1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах, жуулчдад зориулсан бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх, эвентүүдийг зохион байгуулах, шинээр бий болгох.<br>2.Улаанбаатар хотын спорт, соёл урлагийн байгууллагуудтай хамтран ажиллах, бүтээгдэхүүн үйлчилгээг дэмжих.<br>3.Олон улсын болон бүс нутаг, гадаад орны хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулагдаж байгаа хурал зөвлөгөөн, соёл урлагийн арга хэмжээг зохион байгуулах.<br>4.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх. | | | |
|---|---|---|---|
| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оролцооны хэлбэр<br>Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах –Х Шийдвэрлэх –Ш |
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1.Гадаад дотоодын жуулчдыг татах эвентүүдийг зохион байгуулах, арга хэмжээний үр өгөөж, эдийн засаг, нийгэм, соёлын нөлөөллийн судалгаа хийх, тайлагнах; | Арга хэмжээний тоо болон эдийн засгийн үр өгөөж нэмэгдсэн байна. | Г, Т |
| | 2.Жуулчны улирлыг уртасгах зорилгоор аялал жуулчлалын идэвхгүй сарууддад төрөл бүрийн арга хэмжээ санаачлан зохион байгуулах; | Жуулчид, оролцогчдын тоо нэмэгдсэн байна. | Г, Т |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 1.Улаанбаатар хотын соёл урлаг, спортын болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах; | Бүтээгдэхүүн үйлчилгээ жуулчдад хүрсэн байна. | Г, Т |
| | 2.Эвент бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэхэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх; | Эвент бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлсэн байна. | Г |
| 3 дугаар зорилтын хүрээнд | 1.Олон улсын болон бүс нутаг, гадаад хамтын ажиллагааны хүрээнд Улаанбаатар хотод зохион байгуулагдаж байгаа олон улсын хурал зөвлөгөөн, соёл урлагийн уралдаан тэмцээний зохион байгуулалтад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах; | Тухайн арга хэмжээний зохион байгуулалт сайжирсан байна. | Г,Т |
| 4 дүгээр зорилтын хүрээнд | 1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх; | Хууль тогтоомж, дүрэм журмыг хэрэгжүүлэх арга хэмжээ авсан байна. | Г |

МОНГОЛ УЛС ЗӨВШӨӨРӨВ ... ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

| | | | |
|---|---|---|---|
| | 2.Бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэр, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах; | Хууль тогтоомж, дүрэм журмыг хэрэгжүүлэх арга хэмжээ авсан байна. | Г |
| | 3.Төрийн албаны болон төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөн ажиллах; | Ёс зүйн хэм хэмжээ зөрчөөгүй байна. | Г |
| | 4.Удирдлагын хуульд нийцсэн үүрэг даалгаврыг шуурхай биелүүлэх, эргэн мэдээлэх; | Шуурхай хэрэгжүүлж, эргэн мэдээлсэн байна. | Г |
| | 5.Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах; | Архив, албан хэргийг холбогдох журам, заавар, стандартын дагуу хөтөлсөн байна | Г |
| | 6.Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэх, тайлагнах. | Төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан байна. | Г |

| **III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА** | | |
|---|---|---|
| Боловсрол | Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй. | |
| Мэргэжил | - бизнес ба удирдахуй /0413, 0114/;<br>- аялал жуулчлал, чөлөөт цаг /1015/;<br>- соёл судлал /031401/. | |
| Мэргэшил | Төрийн албанд мэргэшүүлэх зохих багц сургалтад хамрагдаж төгссөн байх. | |
| Туршлага | Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан байх бол давуу тал болно. | |
| Ур чадвар | Дүн шинжилгээ хийх | - албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээллийг нэгтгэн дүгнэх, санал зөвлөмж боловсруулах;<br>- мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх;<br>- судалгааны арга зүйн мэдлэгтэй байх;<br>- тоон судалгаанд үндэслэн харьцуулалт, шинжилгээ хийх;<br>- тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийж, нөхцөл байдал,<br>- хувилбарыг тодорхойлох чадвартай байх;<br>- бусад. |

| | | |
|---|---|---|
| | Асуудал шийдвэрлэх | - асуудлыг хууль журам, ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх;<br>- албан тушаалын чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах;<br>- албан үүргээ гүйцэтгэх явцад гарч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох;<br>- үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах;<br>- бусад. |
| | Багаар ажиллах | - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах, үлгэрлэн манлайлдаг байх;<br>- бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, харилцааг бий болгох;<br>- маргаантай асуудалд хүлээцтэй ханддаг байх;<br>- бүтээлч санаачилгатай ажиллах;<br>- бусад. |
| | Бусад | - үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан, ард түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр зүтгэх;<br>- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх;<br>- компьютерийн хэрэглээний программ, мэдээллийн орчин үеийн технологи ашиглах, мэдээллийг шуурхай солилцох;<br>- албан ажлын чиг үүргийнхээ дагуу хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө мэдээлэл өгөх чадвартай байх;<br>- хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай байх;<br>- байгууллагын болон хувь хүний нууцыг хадгалах;<br>- төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулга зүйн чадвартай байх;<br>- кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх. |

| **IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ** | |
|---|---|
| <u>Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:</u><br>Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга | |
| <u>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо</u>:<br>- байхгүй | <u>Бусад харилцах субъект</u>:<br>- яам, агентлагийн холбогдох албан тушаалтан;<br>- нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын холбогдох албан тушаалтан;<br>- төрийн болон төрийн бус байгууллага;<br>- иргэн, хуулийн этгээд. |

МОНГОЛ УЛ[С] ЗӨВШӨӨРӨВ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

<table>
<tr><th colspan="2">V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ</th></tr>
<tr><td>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</td><td>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</td></tr>
<tr><td>Албан тушаал:<br>ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА:<br>...............................<br>2022 оны 05 дугаар сарын 17-ны өдөр</td><td>Байгууллагын нэр:<br>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ<br>Шийдвэрийн огноо: 22 05 11<br>Дугаар: 323</td></tr>
<tr><td colspan="2">Албан тушаалын тодорхойлолтыг баталсан</td></tr>
<tr><td colspan="2">Байгууллагын нэр:<br>НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР<br>Шийдвэрийн огноо: ...............<br>Дугаар: ...............<br>(тамга/тэмдэг)<br>ДАРГА ................................................ Д.БАТСҮХ<br>2020 оны 05 дугаар сарын 17-ны өдөр</td></tr>
</table>